

## ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

### SOME PROBLEMS OF PENALTY POLICY REFORM IN CRIMINAL LAW



#### Х.ГАНБОЛД

Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны  
Шүүхийн Ерөнхий шүүгч

#### GANBOLD KH.

The Chief Justice of Soum and Intersoum Criminal Court of First Instance  
Criminal proceedings in Dornogobi province

**Товч агуулга:** Эрүүгийн эрх зүйн шинэтгэл, өөрчлөлт, шилжилтийн үеийн өнөөгийн нийгэмд Эрүүгийн хуулинд заагдсан ял шийтгэлийн үр нөлөө, нийгмээс тусгаарлахгүйгээр эдлүүлэх ял шийтгэлийн төрлийн чадамжийг дээшлүүлэх асуудлыг хөндөх зорилгоор энэхүү өгүүллийг бичлээ.

**Abstract:** I wrote this Research article because I tried to raise some issues, the effect of a conviction of criminal law in today's society in transition and support the other penalty of imprisonment

**Түлхүүр үгс:** Эрүүгийн хууль, эрүүгийн хариуцлага, ял шийтгэл.

**Key words:** Criminal law, criminaliability, punishment.

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинэчлэл нь зөвхөн тухайн салбар дахь шинэчлэл бус шүүх эрх мэдлийн болон төрийн эрх мэдлийн хууль сахиулах бусад байгууллагын бүтэц тогтолцооны шинэчлэлийг төдийгүй хамгийн чухал нь эдгээр байгууллагын албан тушаалтны хэрэглэх хууль тогтоомжийн шинэчлэлийг эрчимтэй хийхийг бодитой шаардаж буй юм.

Шүүх эрх мэдлийн хувьд шүүхээс хэрэглэх хууль тогтоомжийн шинэчлэл нь нэн чухал асуудал байдаг тул юуны урьд Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн шинэчлэлийн талаар судлаачийн санал бодлоо илэрхийлж байна.

Монгол Улсын Эрх зүйн хөгжлийн шинэ үеийг тус улсад Ардын хувьсгал ялсан, мөн анхдугаар Үндсэн хуулиа боловсруулах ажлаа эхлүүлсэн 1921 оноос тооцож байгаа жишиг нь Эрүүгийн эрх зүйн хувьд ч мөн адил хамааралтай. Өөрөөр хэлбэл, сүүлийн 80 гаран жилийн дотор батлагдан мөрдөгдөж

ирсэн 1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг \*-үүд, 1942, 1961, 2002 оны Эрүүгийн хуулиуд нь хоорондоо залгамж шинжтэй шинэчлэгдсэн талаар судлаачид дүгнэсэн байдаг<sup>1</sup>.

Өнөөдрийн мөрдөгдөж байгаа Эрүүгийн хууль<sup>2</sup> нь хэв маягийн үндсэн үзэл баримтлалын зарим шинж нь өмнөх хуулиудын уламжлал хэвээр хадгалагдсаар байгаа нэг илрэл нь хорих ялыг олон зүйл ангид хэрэглэхээр, шоронд удаан хугацаагаар хорихыг гол хэрэглүүр болгосон, шударга, энэрэнгүй, тэгш эрхийн зэрэг зарчим зарим талаар алдагдсан "харгис хууль" гэж үзэх тодорхой үндэслэлийн талаар эрдэмтэд, хуульчид, иргэд шүүмжлэн бичиж, ярьсаар буйд төрийн эрх баригч, бодлого тодорхойлогч эрхмүүд, улс төрийн голлох хүчнүүд анхаарлаа хандуулж, шинэчлэлийг даруй хийхийг

<sup>1</sup> Д.Зүмбэрэлхам. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчлэлтийн үндсэн үзэл баримтлал (Монголын Эрх зүйн шинэтгэл). УБ., 2003. 485 тал

<sup>2</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002.

шинэ цаг үе шаардсаар байна.

Манай улс “Ял” гэсэн ойлголтоос өөрөөр “Эрүүгийн хариуцлага” гэсэн нэр томъёогоор илэрхийлсэн бөгөөд зорилго нь “иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино” гэж хуульчилжээ<sup>3</sup>.

Монгол Улс хорих ял оногдуулах, биечлэн эдлүүлэх байдлаас хамааран шоронжиж байна. Өнөөдөр шоронгийн тоо, тэнд ял эдэлж буй хүмүүсийн тоо, тэдний нас, хүйсийн байдал ямар байгааг бодитой мэдэх, мэдрэх ёстой. Дэлхийд хөгжингүй орнуудтай харьцуулахад цөөхөн хүн амтай орнуудын нэг атлаа гэмт хэрэг үйлдэн ял шийтгүүлэгчид нь шоронд удаа дараа буюу удаан хугацаагаар ялаа эдэлдэг, хорих ял оногдуулах зүйл анги нь нийгмийн аюул, хор уршгаар хоорондоо харилцан адилгүй ч ял шийтгэл нь ижил зэрэг байдлуудаас хамааран шоронжих байдал тогтвортой байсаар байна.

Тухайлбал: Эрүүгийн хуулийн тусгай ангид нийт 225 үйлдлийг гэмт хэрэг хэмээн хуульчилсан байдаг бөгөөд түүнийг үндсэн, хүндрүүлэх, онцлон хүндрүүлэх байдлаар задалж үзвэл 449 үйлдлийг гэмт хэрэг хэмээн тооцсон байна. Үүнийг зүйлчлэн авч үзвэл Цаазын ялтай 7, хорих ял оногдуулахаар 330, торгох ял 213, албадан ажил хийлгэх ял 44, нэмэгдэл ялын чанартайгаар эд хөрөнгө хураах ялыг 42, тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 65 гэмт хэрэгт оногдуулахаар заасан нь хорих ял оногдуулах төрийн бодлого ямар түвшинд байгааг харуулж байна. Түүнчлэн 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт 25 хорих ангид 6911 ялан ял эдэлж байна<sup>4</sup>.

Хорих ял эдэлж байгаа хүмүүсийн дийлэнхийг буюу 20-35 насны залуучууд сурч боловсрох, гэрлэх, хөдөлмөрлөх идэр насны залуус эзэлж байна. Хөгжингүй, ардчилсан орнуудад

гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан нийт ялын 80 хувийг хорихоос өөр төрлийн торгох ба бусад ял эзэлдэг байхад манайд нийт ялын 70 хувийг хорих ял эзэлдэг талаар судалгаа байна. Тодруулбал Монгол Улсын Шүүхийн 2014 оны шүүн таслах ажиллагааны тайлангаар<sup>5</sup> 2013 онд 7943 хүнд ял шийтгэл оногдуулснаас 6148 хүнд хорих ял оногдуулсан буюу нийт ялын 77.8 хувь, 1034 хүнд баривчлах ял оногдуулсан буюу нийт ял шийтгүүлэгчдийн 13 хувийг тус тус эзэлж байсан бол 2014 оны тайлангаар 8057 хүнд ял шийтгэл оногдуулснаас 6277 хүнд хорих ял оногдуулсан буюу нийт ял шийтгүүлэгчдийн 78.6 хувь, 442 хүнд баривчлах ял оногдуулсан буюу нийт ял шийтгүүлэгчдийн 7 хувийг тус тус эзэлж байна.

Дээрх судалгаанаас харахад Монгол улсад зонхилж гардаг гэмт хэргүүдэд эрүүгийн хуулинд заасан ял шийтгэлийн төрөл нь сонголт багатай, хорих болон баривчлах ял шийтгэлээс өөр төрлийн ял шийтгэл хэрэгжилт хангалтгүй байдлаас хамааран ял шийтгүүлэгчдийн дийлэнх хувийг буюу 85-88 хувийг хорих болон баривчлах ял шийтгэлээр шийтгүүлэгчид эзэлж байна.

Монгол Улсад гэмт хэрэг гарах үндсэн гол шалтгаан нь гэмт хэрэг үйлдэгчийн ядуурал, ажилгүйдэл, архидалт, хууль, эрх зүйн мэдлэг боловсролгүй байдал байсаар удаж байна. Эдгээр шалтгааныг бий болгогч хүчин зүйл нь төрийн ба улс төрийн нам, бизнесийн хүрээн дэх аалзны тор мэт сүлжилдсэн авлигын тогтолцоот ужиг, нийгэмд чиглэсэн эдийн засгийн болон эрх зүйн буруу бодлоготой уялдаж холбогдоно.

Төрөөс гэмт хэргийн үндсэн шалтгааныг бууруулах бүх талын үүргээ зохих ёсоор биелүүлж чадаагүй цагт гэмт хэрэг буурахгүй нь маргаангүй тул тэдгээр шалтгааны улмаас алдаж, эндсэн иргэдийг Эрүүгийн хуулийн харгис ялаар хатуу албадсаар байгаад ёс суртахуунтай иргэн болгоно, гэмт хэргийг багасгана гэвэл ялын зорилго, гэмт хэргийн урьдчилан сэргийлэх гол шугамаасаа үзэл санааны түвшинд хазайх болно.

<sup>3</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002. 45 дугаар зүйлийн 45.3 заалт

<sup>4</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2012 оны тоо бүртгэлийн тайлан.

<sup>5</sup> Монгол Улсын Шүүхийн тайлан. УБ., 2014. 171 тал



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХУЙ



Хятад улс нь дэлхийн хамгийн олон хүн амтай, эрүүгийн хууль нь социалист хэв маягийн шинжтэй атлаа ялын тогтолцоо нь хүмүүнлэг, иргэнлэг, ардчилсан шинжтэй аж. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулинд<sup>6</sup> хорих ял болон бусад ял шийтгэлийн талаар хяналт тавих буюу хэд хэдэн эрх чөлөөг нь 3 сараас 2 жил хүртэл хязгаарлах, 15 хоногоос 6 сар хүртэл баривчлах, 6 сараас 15 жил хүртэл хугацаатай хорих зэрэг ялыг сонгомол байдалтай хэрэглэдэг. Зөвхөн Хятад гэлтгүй бусад хөгжингүй орнуудад хорих ялын доод хугацаа бага байхаас гадна хорихоос бусад төрлийн хөнгөн ялын эзлэх хувийн жин олонхи хувийг эзэлдэг, ялыг заавал сонгож хэрэглэх боломжтой байдлаар заадаг, онц ноцтой хэрэг л биш бол хорих ял аль болох оногдуулахгүй байх жишиг хандлага зонхилж байгааг судлаач, эрдэмтэд цохон тэмдэглэсэн байна.

Нийт ялд хорихоос өөр хөнгөн төрлийн ялын хэлбэрүүд дийлэнхий хувийг эзэлж байхаар, мөн хүнд ялыг эдлэлттэй холбогдуулан өөр төрлийн хөнгөн ялаар солих зэрэг шинэчлэлт хийх нь ардчилалын түгээмэл үнэт зүйлсийн утга агуулга, үзэл баримтлалын бодит хэрэгжилтийн илрэл болохоос гадна олон талын ач холбогдлыг нь давхар тооцох шаардлагатай. Тухайлбал, Нийгмээс заавал тусгаарлахгүйгээр засрах, ухамсарлах боломжийг анх тутам олгоно, залууст алдаандаа ухамсарлах боломжийг олгосноор тэдний ар гэрийн ахуй амьдралд үүсэх төрөл бүрийн ээдрээ, төвөгтэй, эмзэг олон асуудлуудаас урьдчилан сэргийлэхээс гадна хүн амын өсөлт, хөгжилт буюу Монголчууд олуулаа болох, залуус, залуу гэр бүлийн хөгжлийг дэмжих зэрэг нийгэм хамгаалалын чиглэлийн цогц бодлоготой нягт уялдана. Мөн эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой, бас хэмнэлттэй. Нөгөө талаас төрийн үүргийн хангалтгүй хэрэгжилт, буруу бодлогын золиос нь энгийн иргэд болох ёсгүйг болон хэт хатуурхах Эрүүгийн бодлого буюу шоронжуулахад чиглэгдсэн Эрүүгийн хууль нь иргэдээс шүүхэд итгэх итгэлийг бууруулж буй

хүчин зүйлсийн нэг болж байгааг хатуу ухамсарлах нь зүйтэй. Уг чанартаа шүүхдээ биш хуулинд “асуудал” нь байгаа юм.

Иймд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангилалд уялдан ялын төрөл ба тохироог шинээр болон шинэчлэн оновчтой, зөв тогтоох нь зүйтэй.

Эрүүгийн хуульд хийдэлтэй буюу засч, боловсронгуй болгох олон зүйл, заалтууд байгаа. Энд тэр бүгдийг авч үзэх боломжгүй, харин шоронжуулахад чиглэгдсэн зарим зөрчилтэй заалт, хүнд ялтай гэмт хэргийг төлөөлүүлж авч үзэж болох юм.

Улсын хэмжээнд танхайрах гэмт хэрэг тэр дотроо зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэж танхайрах гэмт хэрэг хамгийн их гардаг, Зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл гэх ойлголтыг Монгол Улсын Дээд шүүхийн<sup>7</sup> тайлбараар “зэвсэг” гэдэгт иж бүрдэл, бүтцийн хувьд амьд болон бусад биетийг устгах, гэмтээх, мөн бие хамгаалах болон дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсгийн чанартай бусад зүйл” гэдэгт ахуйн болон аж ахуйн зориулалт бүхий (тухайлбал, хайч, сэрээ, сүх, хөрөө, халив (отвёртка), хүрз, өрөм, лоом, гал тогооны болон сахлын хутга г.м.) эсхүл хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулж болох (тухайлбал, бороохой, ташуур, мод, төмөр, чулуу, шил, зодооны хэрэгсэл, бүх төрлийн химийн шингэн ба хатуу бодис г.м.) эд зүйл, хэрэгслийг ойлгоно. гэж заасан байдаг. Гэтэл дээрх гэмт хэрэгт хүндрүүлэхээр зүйлчлэхдээ зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл буюу өнөөгийн нийгэмд гартаа алив зүйл барьсан болгоныг хамаатуулсан хэрэгслийг нэг зүйл ангид адил ял шийтгэлээр шийтгэхээр тусган шийдвэрлэж байгаа нь олон жилийн хорих ялтай хоригдлуудын тооны өсөлтөд нөлөөлж байна.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга ёсны зарчмыг Эрүүгийн хуульд тууштай хангах байдал зөвхөн дээрх жишээгээр хөндөгдөж байна.

<sup>6</sup>Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хууль. 1997.

<sup>7</sup> Монгол Улсын дээд шүүхийн тогтоол. УБ., 2006. Дугаар 03.



МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛААС  
2015 ОНЫ

Мөн жирийн иргэн нь ял эдэлдэг, эрх мэдэлтэн, албан тушаалтнууд нь ял эдэлдэггүй, эсхүл тэдний эдлэх ял нь тэнгэр, газар мэт ялгамжтай байх нь шударга ёс, тэгш эрхийн зарчимд нийцэхгүй.

Албан тушаалын буюу авилга, хээл хахуулийн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын байдлыг харахад гэмт хэргийн хөнгөн, хүндэвтэр ангилалд хамаарч байгаа нь шударга бус явдал ба энэ нь иргэдийг нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхсан хэлбэр мөн төдийгүй Үндсэн хуульд заасан хууль шүүхийн өмнө иргэн бүр тэгш эрхтэй болон бусад зарчмуудад нийцэхгүй байгааг анхаарах нь чухал байна. Чезаре Беккариагийн<sup>8</sup> хэлснээр...нийгмийн дээд давхаргынхан, эрх баригчид гэмт хэрэг үйлдсэн нь шийтгэгдэхгүй үлдээд байвал харьяат иргэдийн шударга ёс, үүргийн мэдрэмж устаж үгүй болно. Албан тушаалын буюу авилга, хээл хахуулийн гэмт хэрэг нь улс, нийгэм, иргэдийн аюулгүй байдал, амьдрах эрхэд ноцтой аюул учруулахад хүргэдэг, жирийн иргэний үйлдсэн гэмт хэрэгтэй харьцуулашгүй ноцтой үр дагавартай, үйлдлийн арга, хэлбэрээрээ “сонгодог” гэмт хэрэгт тооцогдох учраас тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого хатуу байх ёстой.

Мөн албан тушаалын эсрэг бөгөөд хохирлоор зүйлчлэгдэх гэмт хэргийн ихэнхид нь “зөвхөн үлэмж хэмжээний хохирол” учруулсан бол гэж заасан нь шударга ёс, тэгш эрхийн зарчмын ноцтой зөрчил болно. Энгийн иргэн 108.000 төгрөг хулгайлбал гэмт хэрэг, харин албан тушаалтан төсвийн хөрөнгө, мөнгөнөөс 108.000-аас 5 сая буюу үлэмж хэмжээ хүртэлх мөнгө, хөрөнгө хулгайлбал гэмт хэрэг биш байж болох уу.

Тэнсэгдсэн болон хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд тухайн этгээд “захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдүүлнэ” гэх бүх заалтыг хүчингүй

болгох

Гэмт хэрэг, захиргааны зөрчил 2-ыг адилтгах ямар ч үндэслэлгүй, захиргааны зөрчил гаргасан гэж өмнө үйлдсэн гэмт хэргийнх нь ялыг эдлүүлэх шаардлагагүй бөгөөд хуульд заасан зарчимд нийцэхгүй юм. Гэтэл тухайн заалтаар хичнээн олон этгээдийг ял эдлүүлж байна. Захиргааны зөрчил гаргасан бол тухайн зөрчилд нь Эрүүгийнхээс бусад холбогдох хуульд зааснаар арга хэмжээ авах, хэрэв тухайн этгээд гэмт хэрэг үйлдвэл Эрүүгийн хуулийн дагуу зохих ялаа эдлэх түүнчлэн тухайн этгээд шүүхийн шийдвэрийг үл биелүүлээгүй бол гэмт хэрэгт тооцох хүртэл зохицуулалт байгаа тул одоогийн Эрүүгийн хуулийн 61.5, 62.3, 63.2 зэрэг заалтуудыг шинээр батлагдах хуулинд хүчингүй болгох нь зохистой.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах нийт ялын 77 хувийг хорих ял биш харин эсрэгээр хорихоос өөр төрлийн ялын хэлбэрүүд болох хүн амын суурь ахуй, эдийн засгийн үр ашигтай, эрх зүйн зөв зохицуулалттай ял шийтгэлүүд эзэлж байхаар ялын тогтолцоонд оновчтой зохицуулалт хийх үүднээс судлаач миний бие дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Шоронжуулах явдлыг эрс багасгах, хорих ял эдэлж байгаагүй хүмүүст хорих ял оногдуулах явдлыг аль болох хязгаарлаж, хорих ялыг дангаар бус харин албадан ажил хийлгэх, торгох болон бусад хөнгөн төрлийн ялыг сонгох байдлаар хослуулан тогтоосон гэмт хэргийн бүрэлдэхүүний тоог үлэмж өргөжүүлэх;

Эд хөрөнгийн эрхэнд халдах ял шийтгэлүүдийг биелэгдэх боломжийг олгох үүднээс тодорхой хугацаанд хэсэгчлэн эдлэж байхаар оногдуулах;

Хорих ялыг тодорхой хугацааг эдэлсэн тохиолдолд өөр төрлийн хөнгөн ялаар дүйцүүлэн сольж байх;

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг хохирол барагдуулах боломжгүй байдлаар дахин хохироохгүй байх;

Нийгэмд үнэлэмжтэй ажиллах хүчинг бий болгох зэрэг шинэчлэл шаардлагатай байна.

Монгол Улсын Их хурлаас 2015 оны

<sup>8</sup> Италийн Чезаре Беккариа /1738-1794/ 1764 “Гэмт хэрэг болон шийтгэл тухай”.

12 дугаар сарын 07 ны өдөр шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн талаар санал:

Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө, ажил, албан тушаал, оршин суугаа газар, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй. гэсэн ялын бодлогын суурь зарчмын хүрээнд ял оногдуулалт болон биелэлтэд хоёрдмол санаагүйгээр хэрэгжүүлэх нь чухал.

Гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд тохирох ял шийтгэлийг хуулийн дагуу оноох нь зүйн хэрэг боловч өмнөх эрүүгийн хуулийг хэрэгжүүлэхэд тухайн этгээдэд ял шийтгэл оногдуулахдаа үйлдсэн гэмт хэрэг, учруулсан хохирлоос гадна ялыг ялгамжтай оногдуулах гол шалгуур нь гэмт хэрэгтний хувийн байдал, ажил хөдөлмөр, хөрөнгийн хэмжээ зэргийг харгалзан ялыг оногдуулдаг байсан нь дээрх шударга ёсны зарчмыг зарим талаараа хөндөхөд хүрдэг байсан гэдгийг дурьдая.

Цаашид шинэ хуулийг хэрэгжүүлэхдээ ял оногдуулах, эдлүүлэх үйл ажиллагаанд шударга ёсны үл ялгаварлах зарчмыг үндэслэл болгон ажил хөдөлмөр, боловсрол, хөрөнгө чинээг урьтал шалгуур болголгүй үйлдсэн гэмт хэргийн хэм хэмжээ нийгмийн аюулын бодит байдалд үнэлэлт өгч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Мөн хуулийн Шударга ёсны зарчим бүлэгт хамаарах Гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй гэсэн заалт нь үзэл баримтлалын хувьд шинэчлэгдсэн заалтууд байх ба ял оногдуулах, эдлүүлэх үйл ажиллагаа хувь хүнд чиглэгдсэн байхыг хуульчилсан нь гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдийн ойр дотныхон, гэр бүлийн гишүүдийн эрх зүйн байдлыг эд хөрөнгийн эрхээр хязгаарлагдах байдлыг цэгцлэх шаардлага уг хуулийг хэрэгжүүлэхэд тулгарна.

Иймд эд хөрөнгөтэй холбоотой эрүүгийн хариуцлага болох ял,

албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ хувь хүний эд хөрөнгийн эрхийг бүрэн тодорхойлсны дүнд хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох нь зүйтэй.

Шинээр батлагдсан хуулинд эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл, ялын төрөл зэргийг нарийн тусгасан байна. Үүнээс хамгийн чухал асуудал бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдал болох насанд хүрсэн этгээд, өсвөр насны этгээд, хуулийн этгээд гэсэн ангиллаар тус бүрд ялын төрлийг зохицуулсан нь шинэлэг эрх зүйн зохицуулалт болсон байна.

Мөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээсэн субъектив байдалд нь ялыг ялгамжтай оногдуулах тогтолцоог оруулж өгсөн нь бүх хэрэг маргаанд мэтгэлцэх үйл ажиллагаа ашиглах шаардлагагүй байдлаар тусгасан байна.

Өмнөх хуулийн үйлчлэлд маш өргөнөөр хэрэглэгдэж байсан заалтуудын нэг бол хорих ял оногдуулсан этгээдийг тодорхой хугацаа, шалгуураар биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж үзэн тэнсэх зохицуулалтыг шинэ хуулинд эрүүгийн хариуцлагын албадлагын арга хэмжээний нэг төрөл болгон заавал ял шийтгэл оногдуулахгүйгээр хэрэглэх боломжийг олгосон байдлаар тусгасан байна.

Мөн тэнсэх албадлагын арга хэмжээг хэрэглэхээр заагдсан этгээдийн хүлээх үүрэг, эдлэх эрхийн хязгаарлалтыг нарийн тусгасан нь уг зүйл заалтыг хэрэгжүүлэх этгээд, хяналт тавих эрх бүхий этгээдийн эрх зүйн ухамсарт уг ялын ойлголтыг тодорхой болгож өгсөн байна.

Шинэ хуулинд өмнөх хуулинд ялын төрөл буюу нэмэгдэл ялын төрөлд багтдаг байсан эд хөрөнгө хураах үйл ажиллагааг албадлагын арга хэмжээний нэг төрөл болгон хэрэгжүүлэх боломж, хөрөнгийн ангилал, орлогыг тодорхойлолт, хураагдсан эд хөрөнгийн зарцуулалт зэргийг зохицуулж өгсөн байна.

Цаашид шинэ хуулинд тусгасан хууль тогтоогчдын үзэл санааг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн орсон Олон улсын гэрээ, конвенцид тусгасан хүний эрх, эрх чөлөөг дээдлэх нь хууль дээдлэгч төрийн албан хаагч бидний амин үүрэг гэдгийг илэрхийлж байна.